



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/315

Улаанбаатар хот

Үер, усны ослын аюулаас урьдчилан
сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/800 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Голын урсгал болон тогтоол усанд иргэд осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Маршалын гүүр, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо Зайсангийн гүүр хүртэл Туул голын дагуу 2020 оны 06 дугаар сарын 13-наас 09 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн бүрэлдэхүүнийг хөдөлгөөнт эргүүлээр томилон ажиллуулсугай.

2. Усны ослоос урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийн хуваарийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогчийн 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр баталсан “Үер, усны ослын аюулаас урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийн ажиллах түр журам”-ын дагуу иргэдийг болзошгүй усны ослоос урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийг үр дүнтэй, аюулгүй байдлаа сайтар ханган, зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс /хурандаа Б.Сүхбаатар/, Цагдаагийн газар /хурандаа С.Буянжаргал/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс /А.Ганболд/-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд өргөн хүрээнд сэрэмжлүүлж ажиллахыг Засаг даргын хэвлэл мэдээллийн алба /Б.Мөнхцэцэг/-нд тус тус үүрэг болгосугай

4. Хөдөлгөөнт эргүүлээр ажиллахад шаардагдах 12,105,672 /арван хоёр сая нэг зуун таван мянга зургаан зуун далан хоёр/ төгрөгийн зардлыг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч /Б.Хонгорзул/-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч Д.Бямбадоржид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

D:\2020 on\Zahiramjlaliin BB\Zahiramj.docx

1160200801